



УУЛ УУРХАЙ
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

УУРХАЙ, УУЛЫН БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ, ХААЛТЫН ЖУРАМ

Т.Зууннаст

Уул уурхайн бодлогын газрын ахлах шинжээч

УУЛ УУРХАЙН САЛБАР МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ

УУЛ УУРХАЙН САЛБАР

(2020 оны эхний 9 сар)




20%



73%



69%



94%

* - 2020 оны эхний хагас жил (МБ)

Эх сурвалж: ҮСХ, МБ, ГЕГ

ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО


(2020 оны эхний 9 сар)



Эх сурвалж: СЯ, ҮСХ

АЖИЛЛАГСАД

(2020 оны эхний 9 сар)




53.7 МЯН.

Эх сурвалж: СЯ, ҮСХ, www.legalinfo.mn

ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

ӨНӨӨДӨР

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ



ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

- ОЛГОХ ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ (2020) 40 тз
- ШААРДАГДАХ ХУГАЦАА 35 хоног
- 2020 ОНД ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ 14 тб.₮
- 2020 ОНД ЦУЦЛАСАН, ДУУСГАВАР БОЛСОН 248 тз

ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ


- ✓ ӨРГӨДЛӨӨР
- ✓ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР
- ✓ ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЗАРЧИМ (AUCTION)

БУСАД УЛСАД

- 🇨🇦 өргөдөл
- 🇬🇧, 🇦🇺 СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, өргөдөл
- 🇷🇺 ДУУДЛАГА ХУДАЛДАА

2024

ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ



Хууль, эрх зүйн зохицуулалт



Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль: 14.1.3. “газрын тос болон уул уурхайн төслүүд нь нөхөн сэргээлт, хаалтын менежментийн төлөвлөгөөг тухайн үйл ажиллагаа эхэлж, хаалт хийхээс гурван жилээс доошгүй хугацааны өмнө боловсруулж, тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх”



Ашигт малтмалын тухай хууль: 26.2.3. “хайгуулаар тогтоогдсон ашигт малтмалын нөөцийн хэмжээ, үнэлгээ нь олборлолтоос үүсч болох экологийн хохирлыг нөхөн сэргээхэд хүрэлцэх эсэх”



Ашигт малтмалын тухай хууль: 27.1.12. “энэ хуулийн 48.6.1-д заасан тухайн ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлдээ тухайн уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, дэд бүтцийг хэрхэн бүрдүүлэх болон уурхайн нөхөн сэргээлт, хаалт зэрэгт шаардагдах хөрөнгийн талаар тодорхой тусгасан байх”

Хууль, эрх зүйн зохицуулалт



Ашигт малтмалын тухай хууль: 45 дугаар зүйл. Уурхайг хаах үед тавигдах шаардлага 45.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хаах бол төрийн захиргааны төв байгууллагад нэгээс доошгүй жилийн өмнө мэдэгдэж, энэ хуулийн 10.1.14-д заасан журмын дагуу зохих бэлтгэлийг хангаж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

45.1.1.уурхайн талбайг нийтийн зориулалтаар ашиглахад аюулгүй болгох, байгаль орчныг нөхөн сэргээх талаар холбогдох арга хэмжээг бүрэн авах;

45.1.2.уурхайн эдэлбэр байсан газрыг нийтийн зориулалтаар ашиглахад аюул учирч болзошгүй бол түүнээс сэргийлэх арга хэмжээ авах;

45.1.3.тухайн нутгийн захиргааны байгууллага, эсхүл мэргэжлийн хяналтын албанаас талбайд үлдээхийг зөвшөөрснөөс бусад техник хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд хөрөнгийг талбайгаас гаргах.

45.2.Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас үүсч бий болсон, аюул учруулж болзошгүй газруудыг зохих масштабын газрын зураг дээр нарийвчлан тэмдэглэж, шаардлагатай тэмдэг, дохио, сануулгыг уурхайн эдэлбэрийн орчинд байрлуулах бөгөөд газрын зургийг мэргэжлийн хяналтын алба болон тухайн сум, баг, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгнө.

Хууль, эрх зүйн зохицуулалт



Ашигт малтмалын тухай хууль:

- 10 дугаар зүйлийн 10.1.14 дэх заалт “уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах” гэж,



Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө:

- 2.67.2-т “уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн журмыг олон жишигт нийлүүлэн боловсруулж, мөрдүүлэх” гэж,



Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ын баримт бичиг:

- 3.2.1.10-д “уурхайн нөхөн сэргээлт, уулын үйлдвэрийн хаалтын журмыг олон улсын жишгийн дагуу боловсруулж хэрэгжүүлэх” гэж тус тус заасан.

Хууль, эрх зүйн зохицуулалт



- Захиргааны ерөнхий хуулийн дагуу холбогдох аргачлалаар боловсруулсан.
- Энэхүү журмаар боловсруулах уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн хаалтын менежментийн төлөвлөгөө нь тухайн төслийн орд газрыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл болон байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээтэй нягт уялдана.
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/181, А/458 дугаар хамтарсан тушаалаар батлуулсан.
- Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмыг Захиргааны ерөнхий хуулийн холбогдох заалтын дагуу хянан бүртгүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4530 дугаарт бүртгүүлсэн.

-

Журмын төслийн агуулга

“Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмын төсөл нь 12 зүйл, 1 хавсралттай байна.



Ерөнхий зүйл

- Журмын зорилго, хамрах хүрээ



Хаалтын менежментийн төлөвлөгөө, түүний агуулга, тавигдах шаардлага

- Төслийн тойм, хаалтын зорилго, зорилт
- Хаалтын дараах газар ашиглах зориулалт
- Хаалтын дараах гүйцэтгэлийн физикийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд
- Хаалтын дараах гүйцэтгэлийн химийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд
- Дэд бүтэц, тоног төхөөрөмж, барилга байгууламжийг буулгах, нүүлгэн шилжүүлэх, нураах, аюулгүй болгохтой холбоотой зайлшгүй хийх ажлын төлөвлөгөө
- Төслийн талбай дээр физик, химийн тогтвортой байдлыг хангах, иргэдийн эрүүл ахуй, аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн явцын нөхөн сэргээлтийн нарийвчилсан төлөвлөлт бүхий байгаль орчны нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
- Хаалтын өмнө болон дараах тодорхой хугацаанд уурхайн ажиллагсад болон нөлөөлөлд өртөх иргэдийн талаар авч хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөлт бүхий нийгмийн нөлөөллийг бууруулах төлөвлөгөө
- Уурхайн хаалтын бэлтгэл ажлыг хангахад хангалттай хүрэлцэхүйц шилжилтийн үеийн ажлын нарийвчилсан төлөвлөгөө
- Хаалтын дараах аливаа эрсдлийн үнэлгээ, тэдгээрээс урьдчилан сэргийлэх болон бууруулах арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө
- Хаалтын дараах хяналт шинжилгээ, үнэлгээ, мониторингийн ажлын нарийвчилсан төлөвлөгөө
- Түр болон гэнэтийн хаалтын үед авах арга хэмжээний төлөвлөгөө
- Энэ журмын 5-р бүлэгт заасан хаалтын зардлын нийт тооцоо



Хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулах, санал өгөх, хүлээн авах

- Хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулах
- Хаалтын менежментийн төлөвлөгөөг хянаж санал боловсруулах
- Хянаж санал өгсөн хаалтын менежментийн төлөвлөлөгөөг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх
- Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хаалтын менежментийн төлөвлөгөөг хүлээн авах

Журмын төслийн агуулга



Уурхай, уулын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн явцын болон хаалтын нөхөн сэргээлт

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-д заасан журам, аргачлалын дагуу хийгдэнэ.
- БОАЖ-ын сайдын 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А-138 дугаар тушаалаар батлагдсан "Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал



Уурхай, уулын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн хаалтын зардал

- Хаалтын үеийн зардлын төлөврүүлэлт
- Хаалтын зардлын задаргаа



Уурхайн хаалтын бэлтгэл ажлыг хангах

- Уурхай, уулын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн үйлдвэрийг бүхэлд нь хаах мэдэгдэл хүргүүлэх
- Хаалтын бэлтгэл ажлын хангуулах
- Хаалтын комисс томилох

Журмын төслийн агуулга



Уурхай, уулын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн хаалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх

- Комиссын актыг үндэслэн хаалтын менежментийн нарийвчилсан төлөвлөгөөнд заасны дагуу холбогдох хууль, журам, стандартын дагуу хэрэгжүүлэх
- Хаалтын менежментийн нарийвчилсан төлөвлөгөөнд хяналт тавих
- Хяналтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах



Уурхай, уулын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн хаалт, хаалтыг хүлээн авах

- Түр болон гэнэтийн хаалт хийх
- Хаалтыг хүлээн авах
- Хаалтын дараах үеийн мониторинг, түүний зардал.



Уурхай, уулын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн хаалт дахь иргэд, олон нийтийн оролцоо

- Танилцуулах
- Мэдээллийн санд байршуулах
- Цахим хуудсанд байршуулах

Журмын төслийн агуулга

10
зүйл

Хаалтын дараах орчны хяналт шинжилгээ, арчилгаа, тордолт

- Хаалтын дараах хяналт-шинжилгээ, арчилгаа, тордолт
- Дээрх ажлыг эрх бүхий этгээдээр гүйцэтгүүлэх

11
зүйл

Бусад

- Хаалтын мэдээллийн сан
- Журмыг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

12
зүйл

Хаалтын менежментийн төлөвлөгөөнд хавсаргах баримт бичиг, тушаалын хавсралтаар батлагдсан.

Хаалтын менежментийн төлөвлөгөөний үе шат

■ Хаалтын менежментийн урьдчилсан төлөвлөгөө

- Ашигт малтмалын тухай хуулийн 26.2.3-т заасны дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл авахын өмнө хайгуулын үр дүнгийн тайлангийн хамт
- Ашигт малтмалын тухай хуулийн 27.1.12-т заасны дагуу ордыг ашиглах болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийн хамт

■ Хаалтын менежментийн нарийвчилсан төлөвлөгөө

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3-т заасны дагуу уурхай, үйлдвэрийг хаахаас 3 жилийн өмнө

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА



Монгол Улс, Улаанбаатар хот, Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр



976-(51)-264056



976-(11)-318169



info@mmhi.gov.mn



www.mmhi.gov.mn